

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АВТОМАШИНЫ ТОО



Улаанбаатар хот

2017 он



2016 оны техникийн хяналтын улсын үзлэгт Хан-Уул дүүргийн хэмжээнд 34.4 мянган тээврийн хэрэгсэл хамрагдаж, өнгөрсөн оныхоос 2100 тээврийн хэрэгслээр нэмэгджээ.

Хан-Уул дүүрэгт бүртгэлтэй автомашины тоо сүүлийн 3 жилд дунджаар 15.9 хувиар өсчээ. Тухайлбал, 2014 онд 21.7 хувиар, 2015 онд 19.6 хувиар, 2016 онд 6.5 хувиар өмнөх оныхоос тус тус өссөн байна. Нийслэлийн хэмжээнд техникийн

хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 10.1 хувийг Хан-Уул дүүрэгт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Хүснэгт 1. Автомашины тоо, төрлөөр 2014-2016 он

	2014 он			Автомашины тоо, төрлөөр				Амины автомашин	
	2014 он	2015 он	2016 он	Суудлын	Ачааны	Автобус	Тусгай	2015 он	2016 он
Нийслэлийн дүн	297008	331564	339626	262341	61452	9951	5882	265352	275084
Хан-Уул дүүрэг	27036	32344	34444	26838	5702	1162	742	25451	27316

2016 онд дүүргийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт 34444 тээврийн хэрэгслийн 77.9 хувийг суудлын автомашин эзэлж байгаа бол 16.5 хувь нь ачааны, 3.4 хувь нь автобус, 2.2 хувь нь тусгай зориулалтын автомашин тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Автомашины тоо, ашиглалтын хугацаагаар

	2015 он				2016 он			
	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-аас дээш	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-аас дээш
Нийслэлийн дүн	331564	12306	78560	240698	339626	9104	74891	255631
Хан-Уул дүүрэг	32344	2587	8530	21227	34444	2336	8986	23122

2016 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүүргийн нийт тээврийн хэрэгслийн ихэнх буюу 67.1 хувийг арав ба түүнээс дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд эзэлж байна. Улаанбаатар хотод техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 75.3 хувь буюу 255.6 мянган тээврийн хэрэгсэл нь арав ба түүнээс дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд байна. Үйлдвэрлэгдэж гарсан хугацаанаас хойш 0-3 жил

ашиглаж буй шинэ автомашины тоо дүүргийн хэмжээнд нийт тээврийн хэрэгслийн 6.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.2 пунктээр буурсан дүнтэй байна.

Хүснэгт 3. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он
Нийт орлого	сая.төг	2738.0	1284.9
Зорчигчдын тоо	мян.хүн	7518.2	1840.3
Зорчигч эргэлт	мян.хүн.км	25561.8	6257.0

Дүүргийн нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2016 онд 6257 мянган хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 1840.3 мянган хүн тээвэрлэж, 1284.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Зорчигчдын тоо өмнөх оныхоос 75.5 хувиар буюу 5677.9 мянган хүнээр буурсан, үйлчилгээний орлого 53 хувиар буюу 1453.1 сая төгрөгөөр буурчээ. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт, үйлчилгээний орлогын бууралтад зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлэгч томоохон аж ахуйн нэгж байгууллага татан буугдсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 4. Автобусны буудлын тоо

Дүүрэг	2015 он			2016 он			Стандартын шаардлага хангасан талбайтай зогсоол	Зогсоолын тэмдэгтэй
	Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:			
		Эцсийн зогсоол	Дундын зогсоол		Эцсийн зогсоол	Дундын зогсоол		
Хан-Уул	59	9	50	59	9	50	25	17

Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны дундын болон эцсийн зогсоолын байршлыг тогтоох, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, тогтоосон байршлыг баталгаажуулах асуудлыг холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтарч шийдвэрлэх зорилгоор хийгдсэн үзлэгээр Хан-Уул дүүргийн хэмжээнд 2016 онд нийтдээ 59 автобусны буудал, зогсоол байгааг тогтоожээ. Нийт буудал, зогсоолын 15.2 хувийг эцсийн, 84.7 хувийг дундын зогсоол эзэлж байгаа бөгөөд 42.4 хувь нь стандартын шаардлага хангасан, 28.8 хувь нь автобусны зогсоолын тэмдэгтэй байжээ. Нийслэлийн төвийн 6 дүүргүүдийн хувьд Хан-Уул дүүрэгт хамгийн цөөн буюу 59 буудал, зогсоол байрладаг байна.

Танилцуулга бичсэн:

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Д.Оюунгэрэл